

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар	2
Хоёр. Хүний нөөцийн чиглэлээр	4
Гурав. Ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр	6
Дөрөв. Алба хаагч, ажилтны хууль ёсны эрх ашиг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр	7
Тав. Цалин, нэмэгдэл, урамшууллын чиглэлээр	9
Зургаа. Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр	10
Долоо. Алба хаагчдын сахилга, ёс зүйн чиглэлээр	12
Найм. Дэвшилтэд техник, технологийг үйл ажиллагаандаа ашиглах чиглэлээр	13
Ес. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр	17
Арав. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр	22
Арван нэг. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр	24
Арван хоёр. Дотоодын цэргийн үйл ажиллагааны чиглэлээр	25
Арван гурав. Бусад чиглэлээр	26

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025.07.29

Улаанбаатар хот

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж заасан ба цагдаа, дотоодын цэргийн байгууллага энэ үүргийг хэрэгжүүлэх замаар Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодорхойлсон “Амар тайван, аюулгүй нийгмийг бэхжүүлэх” зорилтод хувь нэмрээ оруулж байна.

“Алсын хараа-2050”, “Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 хөтөлбөр” болон “Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн таван чиглэл”-д үндэсний болон салбарын үр дүнг тодорхойлж, түүнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас оруулах хувь нэмрээ тодорхойлж, алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлээ түүнд уялдуулан энэ онд шинэчилж, бодлого, төлөвлөлтөө боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнд Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага нь Алсын харааг “Иргэдийн итгэлийг хүлээсэн, олон улсын жишигт нийцсэн, мэргэшсэн байгууллага байна”, Эрхэм зорилгыг “Хүний эрхийг дээдлэн шударга ёсыг эрхэмлэж, амар тайван нийгмийг бүрдүүлнэ”, Үнэт зүйлийг “Байгууллагын хувьд: Ёс зүйтэй, мэргэшсэн алба хаагч, ажилтан, Алба хаагч, ажилтны хувьд: Шударга, шуурхай, бүтээлч, хамтын хөгжил”, Уриаг “Амар тайван амьдралын төлөө хамтдаа” гэж тодорхойлон үйл ажиллагаа чиглүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн уламжлал, шинэчлэлийг хослуулан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2025 онд “Хамтдаа хөгжье” уриалгын хүрээнд 1. Хүний эрх, тэгш байдал, 2. Аюулгүй орчин, 3. Мэргэшсэн алба хаагч, 4. Тогтвортой, шуурхай ажиллагаа, 5. Дэвшилтэт технологи, инновац, 6. Алба хаагчийн эрх ашиг, эрүүл мэнд, 7. Арга барил, харилцаа, хандлага, бүтээлч сэтгэлгээ гэсэн 7 үндсэн чиглэлд зорилтыг дэвшүүлсэн. Энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 2,197 ажил, арга хэмжээг 89 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь төрийн цэргийн хууль сахиулах байгууллагуудыг манлайлан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Цагдаагийн ерөнхий газрын даргатай хамтарсан А/71, А/175 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, хүн төвтэй үйлчилгээг бий болгох зорилгоор процессын дахин инженерчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгуулж процессын дахин инженерчлэлийн ажлыг 12 анги, байгууллагад эхлүүлж, судалгаа, шинжилгээний нэгдсэн тайлан, сайжруулалтын санал, зөвлөмжийг боловсруулж /to be загвар/ энэ оны IV дүгээр улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын зорилт 7.4-ийн 3 дахь хэсэгт “Салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа,

шинжилгээний баазыг бэхжүүлсэн байна.” гэж заасныг баримтлан Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд “Инновац, хөгжлийн хэлтэс”-ийг шинээр байгуулж, цахим шилжилтийг эрчимжүүлэх, байгууллагын онцлогт нийцүүлэн дата засаглал, дижитал шилжилт, дэвшилтэд технологи, инновац хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд “Дижитал шилжилт 2025-2029” хийх бодлогын төлөвлөлтийг үндсэн 5 багц (“Дижитал шилжилт хийх”, “Кибер аюулгүй байдлыг хангах, нэгдсэн дэд бүтэц”, “дата төв байгуулах”, “Дата засаглал, Дата суурилсан шийдвэр гаргалт хэрэгжүүлэх”, “Хиймэл оюун хөгжүүлэлт, үйл ажиллагаанд нэвтрүүлэх”) үе шаттай хийж, хэрэгжүүлэхээр боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд дижитал шилжилт хийх төлөвлөлтийн 1-р үе шатын дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд дата засаглал болон дата суурилсан шийдвэр гаргалт бий болгохоор гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулж, дата урсгалын шинжилгээ хийх, өгөгдлийн урсгалын диаграмм, мэдээллийг бүртгэл судалгаа хийх, өгөгдлийн агуулах (Datawarehouse) үүсгэх технологийн орчин бүрдүүлэх, мэдээллийн сангийн өгөгдлүүдийг цуглуулж байршуулах, байгууллагын хэмжээнд дашбоардууд боловсруулж гаргах, алба хаагчдад сургалт орох зэрэг ажлуудыг эхлүүлэн, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/197 дугаартай тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагыг нэгдсэн бодлого, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөл мэргэжлийн албадын уялдаа холбоог хангах асуудлыг шат дараалан хэлэлцэж шийдвэрлэх үүрэг бүхий байнгын үйл ажиллагаатай Бодлогын зөвлөл, дэд зөвлөлийг байгуулсан.

Дэд зөвлөлүүд нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг ойрын болон хэтийн зорилттой уялдуулан хангахын тулд “Захиргаа, санхүү, ар тал эрхэлсэн”, “Стратеги, бодлого дижитал шилжилт эрхэлсэн”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил эрхэлсэн”, “Гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажил эрхэлсэн”, “Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдал эрхэлсэн”, “Алба хаагч ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхол эрхэлсэн”, “Дотоод хяналт, мэдээллийн аюулгүй байдал эрхэлсэн” чиглэлүүдээр байгуулагдсан. Тайлангийн хугацаанд бодлогын зөвлөл 3 удаа, дэд зөвлөлүүд 14 удаа хуралдаж, нийт 38 асуудлыг дэвшүүлэн хэлэлцэж, бодлого, чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Улсын онцгой комиссын энэ оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 6 дугаар хуралдаанаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг, “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Улаанбаатар хот, “20 минутын хот” стандарт бодлогын хүрээнд хэрэгжих 14 хот, 3 дагуул хот, 42 хорооллыг байгуулах шилжилтийн үйл ажиллагаатай уялдуулан, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг”, “Улсын хэмжээнд теле камерын хяналтын нэгдсэн төв, дэд төвүүдийг байгуулах, камержуулах, дэвшилтэд технологи нэвтрүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, судалгаа, санал

дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнийг тус тус шинэчлэн байгуулж эрчимжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны хүрээнд энэ оны эхний 05 сарын байдлаар Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас бусад байгууллагатай байгуулсан гэрээ 12, санамж бичиг 13, нийт 25 гэрээ, санамж бичигт хяналт тавин ажиллаж байна. Үүнээс Цагдаагийн байгууллагаас нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг сахин хамгаалах үндсэн үүргийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролтой хүний нөөцийг бэлтгэх зорилгоор энэ оны 04 дүгээр сарын 22-ны өдөр төрийн болон хувийн хэвшлийн 14 их, дээд сургуулиудтай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Ингэснээр цагдаагийн байгууллага, их, дээд сургуулийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, мэдлэг мэдээлэл солилцох, оюутан, судлаачдын бүтээлч сэтгэлгээг дэмжих, практик туршлагад суурилсан сургалт, судалгааг хөгжүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангах, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх чухал алхмыг эхлүүлээд байна.

Монгол улсын Төрийн албаны зөвлөл байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд Төрийн албаны тухай хууль, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүнг танилцуулах, сургалт, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” зөвлөгөөний төвийн бүсийн зөвлөгөөн Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж санал солилцсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага гадаадын ижил чиг үүргийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор энэ оны эхний хагас жилд нийт 21 орны 56 байгууллагатай уулзалт, айлчлал зохион байгуулж, санал солилцов. Энэ хугацаанд гадаад айлчлалд нийт 35 алба хаагчийг томилон ажиллуулж, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах “Цагдаагийн баг”-ийн 242 алба хаагчийг сонгон шалгаруулж, олон улсын түвшинд бэлтгэл сургалтад хамруулсан.

Мөн Бүгд Найрамдах Чех Улсын “Эйч Кюү Эйч” ХХК-тай хамтран цагдаагийн байгууллагад ашиглагдаж буй зэвсэг, хэрэгсэл, тэдгээрийн ажиллагаа болон сэлбэг хэрэгслийн нийлүүлэлт, зэвсгийн мэргэжилтнүүдийг 5 хоногийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. Үүнээс гадна Бүгд Найрамдах Солонгос Улсын “GMD Soft” компанийн MD-Video программыг худалдан авах гэрээ байгуулж, зураг болон видео мэдээллийн чанарыг сайжруулах технологийг нэвтрүүлэн ажиллав.

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын “Үнэт зүйл” нь “ёс зүйтэй мэргэшсэн алба хаагч, ажилтан” хэмээн тодорхойлж, хүний нөөцийн, ил тод, оновчтой, чадамжид суурилсан бодлогыг хэрэгжүүлж, алба хаагчдын хэрэгцээ, шаардлага нийцсэн хөтөлбөрийн агуулга, мэргэшүүлэх сургалтын чанар үр дүнг сайжруулах, мэргэшсэн, чадвартай алба хаагчдын тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч “Алба хаагч төв”-тэй бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүний нөөцийн менежментийн “ISO 30400-30406” багц стандартад үйл ажиллагаагаа нийцүүлэн, нэвтрүүлэх суурийг бэлтгэх зорилготой ажиллаж байна. Хүний нөөцийн

бодлогын баримт бичгийг шинэчилсэн бөгөөд энэ оноос эхлэн тусгай шалгалтыг төрийн албан зөвлөлтэй хамтран зохион байгуулж байна. Ингэхдээ Манлайлах чадвар, Асуудал шийдвэрлэх чадвар, Хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн талаарх мэдлэг, Дүн шинжилгээ хийх чадвар, Монгол хэлний ярианы болон бичгийн чадвар, Удирдан зохион байгуулах чадвар, Багаар ажиллах чадваруудыг тодорхойлж байгаа ба Төрийн албаны зөвлөлийн байранд Цахим шалгалтын системээр тест хэлбэрээр зохион байгуулж, дүнг өрсөлдөж байгаа нийт алба хаагчид ил тод харах нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын 2025 оны төсөвт тусгуулах орон тооны саналуудыг нэгтгэж офицер 624, ахлагч 1120, энгийн 211, нийт 1955 орон тоог цагдаа, дотоодын цэргийн байгууллагад нэмэгдүүлэх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлснээс 527 орон тоог шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын “Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын хэлтэс ажиллуулах тухай” 14/25 дугаартай гэрээний дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/163 дугаар тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын бүтцэд “Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газар /гэрээт/-ыг нийт 319 алба хаагч, ажилтны орон тоотой шинээр байгуулсан.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоол, Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2010 оны 42/123/246 дугаартай тушаалын дагуу Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь энэ онд 11908, гэрээт 1195, нийт 13103 алба хаагч /офицер 6979, ахлагч 5642, энгийн 482/-ийн батлагдсан орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 11702 алба хаагч үүрэг гүйцэтгэж, 1279 орон тоо /офицер 925, ахлагч 298, энгийн 56/ сул байна. /Офицер - алба, нэгж 364, нийслэл 357, аймаг 148, ДЦ-56, ахлагч- алба, нэгж 179, нийслэл 24, аймаг 18, ДЦ-77/ тус тус байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн нөхөн хангалтыг хийх, нөөц бүрдүүлэх зорилгоор “Цагдаа”, “Цагдаа жолооч”, “Хамгаалалтын ажилтан” мэргэжил олгох сургалтын бүртгэл 2025 оны эхний 06 сар байдлаар 7 удаа зарлаж 1314 иргэнийг нөөцөд бүртгэн, 930 иргэнийг Дотоод хэргийн их сургуулийн харьяа “Ахлагч” мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн мэргэжил олгох сургалтад суралцуулж томилсон.

Алба, газар, хэлтэс, тасаг, хэсгийн дарга, чиглэлийн ахлах, ахлах албан тушаалтны болон офицерын нөөцөд хамрагдах шаардлага хангасан 1459 алба хаагчдад шатлан дэвшүүлэх багц цагийн сургалтыг зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 1386 алба хаагчийг Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын даргын дэргэдэх салбар зөвлөлийн энэ оны Б/02 дугаар “Албан тушаал шатлан дэвшүүлэх нөөцийн жагсаалт батлах тухай” тогтоолоор нөөцөд бүртгэж, Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд байршуулж ил тод байдлыг хангасан. Үүнээс алба хаагчийн гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ, хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүн, чадахуйн зарчим (мерит)-д тулгуурлан Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.1, 2.2-т заасныг үндэслэн удирдах албан тушаалын 100 сул орон тоонд, 4 удаа сонгон шалгаруулалт зохион байгуулж, тэнцсэн 78 алба хаагчийн томилолтын асуудлыг шийдвэрлэсэн.

Мөн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын динамик цахим сургалтын платформын ашиглалт, хөгжүүлэлтийн талаар “Go smart TM” ХХК-тай энэ оны 03 дугаар сарын 24-ний өдөр уулзалт зохион байгуулж, тус программыг Хүний нөөцийн сантай холбох ажлыг эхлүүлээд байна.

ГУРАВ. АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭ

Монгол улсын төрийн албаны тухай хуульд зааснаар алба хаагч нь албан үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдана гэж заасан байдаг. Мөн хуулийн 55 дугаар зүйл зааснаар албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх үүргийг төр хариуцна гэж заасныг үндэслэн Цагдаагийн алба хаагчийн ажиллах орчин, нөхцөлийг сайжруулахын тулд ажлын байрны стандартыг мөрдүүлэх, техник хэрэгсэл, хувийн хамгаалалтыг шинэчлэх, тогтолцоог бий болгож, амьдрах нөхцөлийг цогцоор нь дэмжиж ажилласан.

Түүнчлэн дүрэмт хувцас, хангалтын “Динамик” программыг хүний нөөцийн сантай холбох, дүрэмт хувцасны мэдээлэл шалгах, мөнгөн хангамж авах, хэрэгцээ бодох, размер өөрчлөх, санал хүсэлт илгээх зэрэг officer.police.gov сайтад алба хаагчдын дүрэмт хувцас хангалтын мэдээллийг шинээр нэвтрүүлэх ажлыг 2024 оны 09 дүгээр сард эхлүүлж, 2025 оны 04 дүгээр сард бүрэн дуусгаж үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 141 дүгээр зарлигаар баталсан нийт 68 нэр, төрлийн цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийг 2026 оны II улиралд багтаан бүрэн шинэчлэн олгохоор ажиллаж байна.

Алба хаагчдын ажил үүргийг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангах үүднээс “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар”-ын 2025 оны 108 дугаартай тогтоолын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас 150 ширхэг “Зөөврийн компьютер”, 27 ширхэг “Старлинк” төхөөрөмж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг Аюулаас Хамгаалах Тэнхимээс хандивласан 100 ширхэг зөөврийн принтер хүлээн авч шаардлагатай анги байгууллага, алба хаагчдад тараан олгосон.

Мөн "Таван богд нура" ХХК-тай “4G энгэрийн болон автомашины камер, хяналтын төвтэй шууд холбох серверийн тоног төхөөрөмж” худалдан авалтыг зохион байгуулж, энэ онд 388 ширхэг 4G энгэрийн камер, 49 ширхэг бичлэг хадгалах төхөөрөмж, 131 автомашины камер, бичлэг хадгалах төхөөрөмж, дэлгэц, 783 ширхэг камерын лиценз, 4 ширхэг серверийг хүлээн авч, Нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газрын 101, Эрүүгийн цагдаагийн албаны 1, Баян-Өлгийн аймгийн цагдаагийн газрын шуурхай бүрэлдэхүүний 1 нийт 103 албаны автомашинд гадна, дотор камер, бичлэг хадгалах төхөөрөмж, дэлгэцийг иж бүрэн суурилуулж, Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн газарт 4G энгэрийн камер 302, бичлэг хадгалах төхөөрөмж 24, Экологийн цагдаагийн албанд 4G энгэрийн камер 16, бичлэг хадгалах төхөөрөмж 2, Эрүүгийн цагдаагийн албанд 4G энгэрийн камер 5, бичлэг хадгалах төхөөрөмж 1, Мөрдөн байцаах албанд 4G энгэрийн камер 2, бичлэг хадгалах төхөөрөмж 1, нийт 4G энгэрийн камер 325, бичлэг хадгалах төхөөрөмж 28 ширхгийг тохиргоо хийж, тараан олгоод байна.

Энэ онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээд нийт 147 автомашиныг худалдан авч, парк шинэчлэл хийхээр тендер шалгаруулалтыг явуулж байна. Үүнээс

одоогоор 26 автомашиныг хүлээн авч, үлдсэн автомашиныг 2025 оны III улиралд бүрэн хүлээн авахаар төлөвлөн ажиллаж байна.

Зам тээврийн ослын дуудлага, мэдээлэлд түргэн шуурхай очих, дундаж хугацааг багасгах зорилгоор Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.13 дахь заалтад тусгасан ажлын хүрээнд 9 дүүргийн замын цагдаагийн хэлтэст 16 ширхэг “Surron” (цахилгаан дугуй) тээврийн цагдаагийн албанд, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэсэн “Моннис моторс” ХХК-наас “Ниссан сильфи” маркийн тусгай тоноглол бүхий 17 автомашиныг Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Орон нутгийн замын хяналтын хэлтсийн Хөдөлгөөнт хяналтын тасагт, Сүхбаатар дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс “Surron ultra bee” маркийн 1 ширхэг цахилгаан дугуйг Сүхбаатар дүүргийн цагдаагийн газарт, Хэнтий аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, Засаг дарга нарын зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж, “Приус-30” маркийн тээврийн хэрэгсэл шийдвэрлэж өгснийг Хэнтий аймгийн цагдаагийн газарт тус тус хүлээлгэн өгсөн.

Алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “Сургалт, соёл спортын цогцолборын барилга /Улаанбаатар хот/”-ын зураг төсвийг хийж гүйцэтгэх, Хээрийн сургалтын хэсэгт дулааны улиралд ашиглах сургалтын байгууламжийн ажил гүйцэтгэх, Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих Цагдаагийн ерөнхий газрын “Оч” зуслангийн их засваруудыг хийж гүйцэтгэх ажлын тендер сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулж, шалгуур үзүүлэлт хангасан байгууллагуудтай гэрээ байгуулж ажилласан байна.

Мөн Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын цагдаагийн хэлтсийн байр 1, Архангай аймгийн цагдаагийн газарт Эрүүлжүүлэх саатуулах байр 1, Баянхонгор аймгийн Богд, Жаргалант, Өвөрхангай аймгийн Богд, Хужирт, Хэнтий аймгийн Батноров сумуудын сум дундын цагдаагийн тасгийн барилга 5, нийт 7 барилгыг 2025 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Түүнчлэн улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаас санхүүжих “Энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн багийн ашиглах техник, зэвсэг, галт хэрэглэл, тоног төхөөрөмж” худалдан авах төсөл, арга хэмжээг 31 багц болгон зохион байгуулж, одоогоор 30 багцад (үүнээс 52 тээврийн хэрэгсэл) 20 аж ахуйн нэгж, байгууллагыг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, үлдсэн 1 багцад сонгон шалгаруулалтыг явуулж байна. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 96.7 хувьтай байна.

ДӨРӨВ. АЛБА ХААГЧ, АЖИЛТНЫ ХУУЛЬ ЁСНЫ ЭРХ АШИГ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдаас албан үүргээ хэрэгжүүлэх явцаа гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон талаар болон шалтгаан нөхцөлийг судалж “Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөө”-г Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулан, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдаас энэ оны эхний хагас жилийн байдлаар албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон 215 алба хаагчид утсаар, 14 алба хаагчид биечлэн зөвлөгөө өгч, “Хаан даатгал” ХХК-тай байгуулсан гэнэтийн ослын даатгалын мэдээллийг “Алба хаагчдын чөлөөт индэр” фейсбүүк хязгаарлалттай группт мэдээлэл байршуулж, албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа 6 алба хаагчид эрх зүйн туслалцаа үзүүлсэн байна. Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр баталсан “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын Ахмадын хороотой 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-ний 3.7 дахь заалтын хүрээнд албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэрэгт холбогдсон 6 алба хаагчид өмгөөллийн үйл ажиллагаа явуулж буй ахмад ажилтнуудаас үнэ төлбөргүй өмгөөллийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж буй “24/3 Зөв угаа” аян, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/110 тоот тушаал “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээ “Зохистой биеийн харьцааг хэвшүүлье”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, “Зөв хандлага-Зөв соёл”, “Зөв дадал-Эрүүл бие-Эрч хүч” аян, өдөрлөгүүдийг зохион байгуулан, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт төв, орон нутгийн 10847 алба хаагч болон тэдний гэр бүл гишүүн, үүнээс НҮБ-ын ажиллагаанд оролцох 315 алба хаагчдыг нарийн үзлэг, шинжилгээнд хамрагдуулсан байна.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт, судалгаа, зөвлөгөө, үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Нийт 4,629 алба хаагч сургалтад хамрагдаж, 3,585 алба хаагч судалгаанд оролцсон, 1,105 алба хаагч ганцаарчилсан зөвлөгөө авчээ. Мөн удирдах ажилтнуудын удирдлагын арга барилын судалгаа хийж, иргэдэд чиглэсэн сургалт, зөвлөгөөнд 1,200 гаруй хүн оролцсон. Түүнчлэн, МУИС-тай хамтран оюутны дадлага зохион байгуулж, 172 сэтгэл зүйч оролцсон “Сэтгэл зүйчдийн нэгдсэн зөвлөгөөн”-ийг 2025 оны 5 дугаар сард амжилттай зохион байгуулжээ.

Цагдаа, дотоод цэргийн байгууллагын алба хаагч, ажилтныг орон сууцжуулах ажлын хүрээнд “Төр, захиргааны байгууллагатай хамтран алба хаагч, ажилтныг хөнгөлөлттэй болон түрээслээд өмчлөх нөхцөлөөр орон сууцанд хамруулах, орон сууцны зээлийн хүсэлтийг шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлж, тэдний нийгэм, эдийн засгийн баталгааг хангах ажлыг үе шаттай зохион байгуулах” ажлыг байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд ипотекийн зээлд 11, хөнгөлөлтөөр үнээр 21 алба хаагчийг орон сууцанд тус тус хамруулсан ба Баянгол дүүргийн цагдаагийн газар тус дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр 772 мкв газарт орон сууц барихаар зураг төслийн ажлыг гүйцэтгэж эхлүүлсэн, Орхон аймгийн цагдаагийн газар хөнгөлөлттэй үнээр буюу 1м2-ын үнэ 1,9 сая төгрөгөөр 13 алба хаагчийг хамруулахаар гэрээ байгуулж, Өмнөговь аймгийн цагдаагийн газар алба хаагч, ажилтанд хөнгөлөлттэй үнээр 120 айлын орон сууц бариулахаар төлөвлөн, орон сууцны барилгын зураг төсвийг батлуулж, төсвийг 2025 оны эхний хагас жилд тусгуулсан байна.

Мөн “Зайсан” төслийн 320 айлын орон сууцанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 180 алба хаагчийг хөнгөлөлттэй үнээр хамрагдуулсан, одоогийн байдлаар

барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж, 111 дүгээр блок 16, 112 дугаар блок 14 дүгээр давхартаа тус тус ажиллаж байна. Уг орон сууц энэ оны 04 дүгээр улиралд ашиглалтад орохоор төлөвлөж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд “Ахлагч” бүрэлдэхүүнийг хамруулах 16 давхар, 1 орцтой, 2 блок, 256 айлын орон сууцны барилгын гүйцэтгэгч “Сүмбэр цамхаг” ХХК-тай санамж бичиг байгуулж, шавь тавих ёслолын арга хэмжээг зохион байгуулан барилга угсралтын ажил хийгдэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаас 2024 оныг “Ахлагчийн жил” болгон зарласантай холбогдуулан санхүү ар талын албанаас Автобаазын Техник үйлчилгээ, засварын хэлтсийн цагдаа жолооч, засварчин 1 алба хаагчид байшин барьж өгөх төслийг санаачлан, тус албаны алба хаагчдаас нэг өдрийн цалинг сайн дурын үндсэн дээр хандивлан, 380в хүчдэлийн цахилгаантай 64м2 амины орон сууцыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэн 2025 энэ оны 02 дугаар сарын 11-ний өдөр дуусгаж, хүлээлгэн өгсөн. Мөн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын “Ахлагчийн дэд зөвлөл”-өөс “Бид нэг сэтгэлтэй хамт олон” уриа дор хамт олны дэмжлэгтэйгээр “Амины орон сууц барих” ажлын хүрээнд алба хаагчдын сайн дурын үндсэн дээр 1 ахлагч алба хаагчдад амины орон сууц барьж өгч, алба хаагчдын нийгмийн баталгааг дэмжиж, амьдрах орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

ТАВ. ЦАЛИН, НЭМЭГДЭЛ, УРАМШУУЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2025 онд төсвийн урсгал зардлыг 658.1 тэрбум (бараа, үйлчилгээний зардал 609.9, урсгал шилжүүлэг 48.2), хөрөнгө оруулалтын зардлыг 41.6 тэрбум (барилга, байгууламж 9.9, их засвар 2.1, тоног төхөөрөмж 29.6) нийт 699.8 тэрбум төгрөгөөр батлуулсан.

Үүнээс: Урсгал засварын зардлыг 2.2 дахин, тээвэр шатахууны зардлыг 2 дахин, дотоод албан томилолтын зардлыг 79 хувиар, нормын хувцасны зардлыг 53 хувиар, бичиг хэргийн зардлыг 37.9 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 34 хувиар тус тус нэмэгдүүлж батлуулсан боловч бичиг хэрэг, томилолт, байрны түрээс, даатгал, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлууд явуулсан саналаас 10-50 хувиар буурч батлагдсан тул хүрэлцэхгүй хүндрэл үүссэн хэвээр байна.

Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор албан тушаалын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлэн шинэчлэн тогтоож, энэ оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс алба хаагчдын цалинг 6 хувиар нэмэгдүүлж, Засгийн газрын 2024 оны 202 дугаар тогтоолоор цолны ангиллыг тус бүр 2 хувиар нэмэгдүүлж, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-д алба хаагчдын мэргэжлийн зэргийн нэмэгдлийг олгох зохицуулалтыг тусган, алба хаагчдын эрх зүйн мэдлэг, бие бялдар, биеийн жингийн индексээр 2 жилд 1 удаа шалгалт авч, тэнцсэн нийт алба хаагчдын 20 хувьд ажилласан жилээс хамаар 5-25 хувийн нэмэгдэл олгож, Цагдаагийн албаны тухай хуулийн 91.7-д зааснаар цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан хугацааг, алба хаасан хугацаанд оруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/212 дугаар тушаалаар цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагад 24 цагаар эргүүл, жижүүр, харуулын үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдад 20,000 төгрөг, бусад алба хаагчдад 10,000 төгрөгийн хоолны зардлыг олгож, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/202 дугаар тушаалаар

зарим алба хаагчдын онцгой албаны нэмэгдлийг 15 хувиас 20 хувь болгон өөрчлөлт оруулан урамшлуудыг олгож байна.

Энэ ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/186 дугаар тушаалаар Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Туршилтын хугацаагаар ажиллуулах (код 903)”, “Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох (код 924) журам”, мөн даргын 2025 оны А/187 дугаар тушаалаар “Цалингийн зэрэглэл нэмэгдүүлэх албан тушаалын жагсаалт”-д тус тус өөрчлөлт оруулсан.

ЗУРГАА. СУРГАЛТ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Цагдаагийн байгууллагаас “Хүн төвтэй” хөгжлийн үзэл санаанд нийцсэн төрийн албаны реформын зорилтын хэрэгжилтийг хангах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, байгууллагын үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд албаны сургалтын хөтөлбөрийг “20:80” зарчим буюу 20 хувийн онол, 80 хувийн практик, дадлага сургалтад түшиглэн хэрэгжүүлж байна.

Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/442 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Алба хаагчийг бэлтгэх, албаны сургалт явуулах” (код-116), мөн даргын 2025 оны “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/70 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчдын ажлын байрны сургалтын цаг, сэдвийн нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу алба хаагчдыг сурган дадлагажуулах, мэргэшүүлэх, ур чадварын сургалтуудыг зохион байгуулж энэ оны эхний хагас жилийн биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна. Үүнд:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын ажлын байрны сургалтын төлөвлөгөөний дагуу алба хаагчдад мэдлэг олгох 460 удаагийн сургалтад 79910, хүний эрх ба жендерийн 134 удаагийн сургалтад 20906, алба хаагчийн сахилга ёс зүйн 130 удаагийн сургалтад 22194, албаны бэлтгэл тактик эзэмшүүлэх 369 удаагийн сургалтад 23410, бие бялдар, эрүүл мэнд сэтгэлзүйн бэлтгэлийн 196 удаагийн сургалтад 29395, зорилтод бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, насанд хүрээгүй хүүхэдтэй харьцах 26 удаагийн сургалтад 3380, шинээр томилогдсон алба хаагчийг сурган дадлагажуулах 293 удаагийн сургалтад 3305 алба хаагчийг тус тус хамруулж, 1608 удаагийн сургалтад давхардсан тоогоор 182500 алба хаагчийг хамруулсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд эрүү, хэв журмын болон замын цагдаагийн мэргэжлийн ажиллагааны ур чадвар, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх арга зүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, баривчлах ажиллагааны арга тактик, олон нийтийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, дадал, хамтарсан ажиллагааны төлөвлөлт, шуурхай зохицуулалтын чадвар, албан ёсны бичиг хэрэг, баримтжуулалт, процессын мэдлэг олгох сургалт зэрэг нийт 144 удаагийн сургалтад 7751 алба хаагчийг хамруулж, эхний хагас жилийн байдлаар 62.2 хувьтай дүгнэгдэж байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 9 төрлийн 49 удаагийн сургалтад 12606 алба хаагч, 1188 иргэнийг тус тус хамруулсан. Эхний хагас жилийн байдлаар 73.4 хувьтай дүгнэгдэж байна.

Мөн Монгол Улсын Гэрээт харуул, хамгаалалтын тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Б/586 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Харуул, гэрээт албаны” мэргэжил олгох чадамжийн сургалтыг зохион байгуулж, 8 байгууллагын 63 иргэнээс шалгалт авч, тэнцсэн иргэдэд “Гэрчилгээ” олгосон. Мөн Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Тээврийн цагдаагийн албаны захиалгаар “Олон нийтийн цагдаагийн ажилтан” бэлтгэх сургалтыг зохион байгуулж, төгсөлтийн шалгалт, тайлан хамгаалалтаар нийт 84 иргэнд “Гэрчилгээ” олгосон.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/122 дугаар тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын дунд 2025 онд зохион байгуулах соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, энэ оны эхний хагас жилийн байдлаар Сүлд-соён гэгээрүүлэх хэлтсээс цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр анги, байгууллагуудаас 78, хамтран ажилладаг албан байгууллагаас 11 нийт 89 хүсэлтэд уран бүтээлээр дэмжлэг үзүүлэн, арга хэмээг зохион байгуулж ажиллаа. Тухайлбал:

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хүүхэд багачуудыг дэлгэцийн хамаарал, түүнээс шалтгаалсан эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн сөрөг үр дагавар, цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх “Ухаалаг хэрэглээний аялал” хүүхдийн сургамжит жүжгийг найруулан тавьж, нийт 1560 хүүхэд, 62 эцэг эхэд, алба хаагчдын стресс, ажлын алжаалыг тайлах, тэдний дунд соёл урлагийг таниулан сурталчлах, урлаг, гоо зүйн хүмүүжил олгох зорилгоор нийслэлд үйл ажиллагаа явуулдаг соёл урлагийн байгууллагуудаас зохион байгуулдаг үзвэр үйлчилгээ, тоглолт, арга хэмжээг үзүүлэх чиглэлээр Дуурь бүжгийн эрдмийн театрын “Трубадур”, “Ламбагайн нулимс” зэрэг дуурь, “Балетын гала”, Монгол улсын филармоны “Морин хуурын чуулга”, “Баянмонгол биг бэнд” зэрэг тоглолтуудыг давхардсан тоогоор 327 алба хаагч, ажилтан, тэдний гэр бүлийн гишүүдэд, хугацаат цэргийн алба хаагчдад 50 хувийн хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн 47 анги байгууллагын 48 эмэгтэй алба хаагчдын дунд “Албаа гоёсон бүсгүй” тэмцээн, 30 анги байгууллагын давхардсан тоогоор 85 алба хаагчдын дунд “Мистер-2025” тэмцээнүүдийг зохион байгуулж, нийслэлийн 9 дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагч, ажилтан, тэдний гэр бүл, ахмад ажилтнуудад “Ухаарлын 9 хором” лекц-концертыг сэтгэл зүйч, гэр бүл судлаач Г.Наранбаатартай хамтран зохион байгуулж, нийт 2590 алба хаагч, ажилтан, тэдний гэр бүл хамрагдсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хүч спорт хорооны баг тамирчид Монголын Пауэрлифтингийн нэгдсэн холбооны Классик хэвтээ шахалтын 7 дахь удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээн, Классик Пауэрлифтингийн 10 дахь удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээн, “Жүдо бөх”-ийн насанд хүрэгчдийн 2025 оны 11 дэх удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээн, Буудлагын Улсын аварга шалгаруулах тэмцээн, Монголын Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн 2025 оны Улсын аварга шалгаруулах тэмцээн, ОХУ-ын Красноярск хотод болсон 2025 Иван Ярыгины нэрэмжит цомын төлөө “Чөлөөт бөх”-ийн тэмцээн, Монголын мөсөн сурын холбооны 2025 оны олон

улсын аварга шалгаруулах зэрэг олон улсын тэмцээнүүдэд 43 алба хаагч бэлтгэл ханган оролцож, нийт 10 алтан медаль, 20 мөнгөн медаль, 26 хүрэл медаль тус тус хүртэж, амжилттай оролцсон байна.

ДОЛОО. АЛБА ХААГЧДЫН САХИЛГА, ЁС ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдаас энэ оны эхний хагас жилийн байдлаар 436 сахилгын зөрчилд 529 алба хаагч холбогдсон нь урд оны мөн үеэс зөрчил 58 нэгжээр буюу 15.3 хувь, алба хаагч 95 нэгжээр буюу 21.8 хувиар тус тус өссөн байна. Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын 384 буюу 72.5 хувийг офицер, 142 буюу 27 хувийг ахлагч, 3 буюу 0.5 хувийг энгийн ажилтан эзэлж байна. Нийт сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын 500 буюу 95 хувь нь эрэгтэй, 29 буюу 5 хувь нь эмэгтэй алба хаагч байна. Нийт бүртгэгдсэн сахилга, ёс зүйн зөрчлийн 85 буюу 16 хувь нь удирдах албан тушаалтан байх ба сахилгын зөрчлийн 305 буюу 70 хувийг дотоодын хяналтаар, 131 буюу 30 хувийг гадны хяналтаар илрүүлсэн байна.

Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын 235 буюу 44.4 хувьд сануулах, 215 буюу 40.6 хувьд албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, 18 буюу 3.4 хувьд албан тушаал бууруулах, 21 буюу 4 хувьд цол бууруулах, 28 буюу 5.2 хувьд цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах, 12 буюу 2.4 хувьд албанаас халах сахилгын шийтгэл тус тус оногдуулж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдаас 46 алба хаагч сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болохоос өмнө давтан зөрчил гаргасан нь нийт зөрчил гаргасан алба хаагчдын 8.7 хувийг эзэлж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчтай холбоотой 1174 өргөдөл, гомдол хүлээн авч, 1363 алба хаагчид холбогдсон нь урд оны мөн үеэс өргөдөл, гомдол 147 буюу 11.1 хувь, холбогдон шалгагдсан алба хаагч 133 буюу 8.9 хувиар тус тус буурсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар 753 албаны шалгалтад 1577 алба хаагчийн холбогдуулан шалгаснаас 625 албаны шалгалтыг шийдвэрлэж, 128 албаны шалгалт ажиллагаанд байна. Нийт шийдвэрлэсэн 625 албаны шалгалтад 1061 алба хаагчаас буруутай үйл ажиллагаа тогтоогдсон 525 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулж, буруутай үйл ажиллагаа нь тогтоогдоогүй 537 алба хаагч (нотлогдоогүй 446, нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан 26, хугацаатай үүрэг даалгавар өгсөн 65)-ийн нэр төрийг сэргээж ажилласан байна.

Энэ онд цагдаа, дотоодын цэргийн 5 анги, байгууллагад төлөвлөгөөт бүрэн, 5 анги, байгууллагад гүйцэтгэлийн шалгалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хуваарийг батлуулснаас эхний хагас жилийн байдлаар 3 удаагийн гүйцэтгэлийн шалгалт явуулж, төлөвлөгөөний биелэлт 60.0 хувьтай хэрэгжсэн байна.

Түүнчлэн иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж цагдаагийн алба хаагч, байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлын хүрээнд төлөвлөгөөт бус хэсэгчилсэн шалгалтыг 6 удаа зохион байгуулж, дүнг удирдлагад танилцуулан шийдвэрлүүлж ажиллаа.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга, ёс зүйг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, бууруулах, зөрчлийг давтан гаргуулахгүй байх зорилгоор нийт 21 удаагийн “Зөвлөмж”-ийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад хүргүүлж, алба хаагчдын албандаа итгэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх зорилгоор “Албаны соёл” нөлөөллийн арга хэмжээ, алба хаагчдын сахилга ёс зүйн зөрчлийг бууруулах чиглэлээр “Харилцан хүндэлье” аянуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 71 анги байгууллагын алба хаагчдад 76 ажил арга хэмжээг төлөвлөн хийж, 37 анги, байгууллагын нийт бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг шалгаж, “Багаа хамтдаа хөгжүүлье”, “Удирдлагын багийн хамтын ажиллагаа”, “Хүндлэл надаас эхэлнэ” зэрэг сургалтуудад 62 удирдах албан тушаалтнуудыг хамруулсан байна.

Мөн алба хаагч, ажилтан нараас архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гаргаж байгаа сахилга, ёс зүйн зөрчлийг бууруулах, тэдэнд согтууруулах ундааны зүйлийн талаар зөв ойлголт, хандлага төлөвшүүлэх, сэтгэлгээг өөрчлөх зорилгоор “Зөв хандлага-Зөв соёл” аяныг зохион байгуулж, 17 анги байгууллагын албаны бэлэн байдлыг шалгаж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд үйлдэгдэж буй архидан согтууралтай холбоотой сахилгын зөрчил болон гэмт хэрэг, зөрчлийн талаар алба хаагчдад мэдээлэл хийж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөгөө, ажлын чиглэл өгч, цагдаагийн тангараг давтан өргүүлж ажилласан.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар прокурорын байгууллагаас хууль, тогтоомж зөрчсөн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тогтоож, арга хэмжээ тооцуулах чиглэлээр харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 331 алба хаагчид холбогдуулан 51 шаардлагыг ирүүлснийг цахим системд бүртгэн хяналт тавьж, дүн шинжилгээ хийсэн талаарх танилцуулгыг саналын хамт дарга удирдлагад танилцуулсан.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг арга хэмжээний төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2025 онд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлийг хагас жилийн явцын тайланг нэгтгэж, Авлигын эсрэг үндэсний сүлжээ khutulbur.iaas.mn цахим сайтад нотломжийн хамт байршуулсан.

Цагдаагийн төв байгууллагын 126 тусгай дугаарын утсанд 2025 оны эхний жилийн байдлаар талархал 0, санал 0, хүсэлт 0, гомдол 10, мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хүлээн авч, нийт 10 алба хаагчдад холбогдуулан албаны шалгалтыг явуулахад 3 алба хаагчид Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.1 дэх хэсэгт зааснаар “Сануулах” сахилгын шийтгэл оногдуулж, 7 алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй байна.

НАЙМ. ДЭВШИЛТЭД ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА АШИГЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Засгийн газраас баримталж байгаа бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаандаа их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, шийдвэр гаргалтад туслах хиймэл оюун нэвтрүүлэх ажил, арга хэмжээнд чиглэж байна. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд дата

засаглал хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулах, өгөгдөл цуглуулах үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэх зэрэг зөвлөх үйлчилгээ авч замын зураглалаа гаргасан бөгөөд энэ онд байгууллагын хэмжээний нэгдсэн өгөгдлийн агуулах /Data warehouse/ үүсгэхээр ажиллаж байна. Мөн гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчил, дуудлагын мэдээлэл дээр шийдвэр гаргахад туслах мэдээллийн самбар /дашбоард/ боловсруулж нэвтрүүлсэн.

Цагдаагийн байгууллага нь иргэдэд үзүүлэх үйлчилгээг олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, үйлчилгээний чанар, хүртээмжийг тасралтгүй сайжруулахын зэрэгцээ шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд тулгуурлан, ард иргэдийн итгэл, хүлээлт, шаардлагад нийцүүлэн ажиллахыг зорьж байна. Үүний хүрээнд үйл ажиллагаандаа салбарын онцлогт нийцсэн инноваци, шинэ технологийг нэвтрүүлж, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан болон их өгөгдлийг үр ашигтай ашиглахаар төлөвлөж байна.

Энэ ажлын хүрээнд иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хүний эрхийн зөрчлийг бууруулах зорилгоор цагдаагийн байгууллага хиймэл оюун ухаанд суурилсан “Зөрчил AI” системийг хөгжүүлж байна. Уг системээр дамжуулан алба хаагчид хуулийг зөв хэрэглэх, хүний эрх, тэгш байдлыг хангах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн ба зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 7,500 алба хаагчдад эрх олгуулж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд шаардагдах журам, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, зааварчлага, аргачлал зэрэг 10 төрлийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. Мөн Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл, заалтад нийцсэн, гэмт хэргийн (AI) цахим гарын авлагын программ хангамжид суурилсан мөрдөн шалгах ажиллагааны “Ажлын даалгавар”-ын төслийг боловсруулж, уг цахим гарын авлагын программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж байна.

Мөрдөн шалгах ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх чиглэлээр “Чимэгэ систем ХХК”-тай хамтран мэдүүлэг авах үед яриаг бичвэрт хүргүүлэх (Real time) технологийн системийг нэвтрүүлсэн. Мөрдөн шалгах ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлснээр иргэдийн мэдүүлгийг шууд бичвэрт буулгах боломж бүрдэж байна. Энэ нь иргэдийн хэлсэн үг бүр үнэн зөв, алдаагүй тэмдэглэгдэх, мэдүүлэг өгөх үйл явц илүү ойлгомжтой, шударга болох, улмаар цаг хугацаа хэмнэх ач холбогдолтой юм.

Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд Монгол Улсын Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар 7, Засгийн газрын 2023 оны “Журам, аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад зааснаар цагдаагийн байгууллагаас 14, нийт 21 төрлийн лавлагаа, үйлчилгээг цахимаар үзүүлэхээр тусгагдсанаас төрийн үйлчилгээний “E-Mongolia” нэгдсэн системд 20 үйлчилгээ, лавлагааг холбож, Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын “Лавлагаа”, “Тодорхойлолт, баримтын хуулбар” зэрэг 2 багц, 7 үйлчилгээ, нийт 27 лавлагаа, үйлчилгээг тус тус холбож, иргэд цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.

Төрийн цахим үйлчилгээний “E-Mongolia” системд цагдаагийн байгууллагад хандах цэсийг шинээр үүсгэж, иргэдээс өргөдөл, гомдлыг цахимаар харьяалал харгалзахгүй хүлээн авч, шийдвэрлэх технологийн шийдлийг бүрдүүлж, хэвийн ажиллагааг хангасан. Мөн эрүүгийн хэргийг цахимжуулах, мөрдөн шалгах эрх бүхий алба хаагч нарын ажлын ачааллыг бууруулах, цаг хугацааг хэмнэх зорилгоор “Төрийн үйлчилгээний нэгдсэн E-Mongolia” системээс цагдаагийн эрх бүхий алба хаагч 90 төрлийн лавлагаа, мэдээллийг

авч, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд ашиглах боломжтой болж, өнөөдрийн байдлаар 49,214 лавлагаа, тодорхойлолтыг эрх бүхий алба хаагчид олгосон байна.

Мөн иргэдэд төрийн үйлчилгээг хялбар, чирэгдэлгүй хүргэх зорилгоор “Нью Компас” ХХК-тай хамтран жолоодох эрхийн үнэмлэхийг автомат киоск машинаар хэвлэх гэрээ байгуулан, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 2 байршилд автомат киоск байршуулан, жолоодох эрхийн үнэмлэхийн хугацаа сунгах, нөхөн авах, солиулах үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх туршилтын ажлыг зохион байгуулснаар төрийн үйлчилгээ иргэдэд ойртож, иргэд жолоодох эрхийн үнэмлэхээ 2-3 минутад газар дээр нь шууд хэвлэн авах боломжийг бүрдүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлийг илүү хурдан, үнэн зөв тогтоож, гэм буруугүй иргэдийн эрхийг хамгаалан, гэм буруутай этгээдийг шударгаар илрүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор Шүүх шинжилгээний ерөнхий газарт биологийн дээжийн сан байгуулж, энэ онд 19,000 иргэний дээжийг “Генетик мэдээллийн сан”-д оруулан ажиллаж байна.

Иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллээс хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, эргүүлийн үйл ажиллагааг илүү ил тод, үр дүнтэй болгох зорилгоор нутаг дэвсгэрийг квадратын системд оруулж, эргүүлийн нэгдсэн байршлыг цахимд шилжүүлэх, кодлох ажлыг зохион байгуулж, цахим хяналтын “GPS”, дуудлага, мэдээллийн “ECS” зэрэг программ, хангамжид хөгжүүлэлт хийж, цахимаар эргүүлийн чиглэлд хяналт тавих, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг шийдвэрлэхэд хохирогч болон хүүхэд тус бүрд аюулын зэргийн үнэлгээ хийх, Төрийн мэдээлэл солилцооны “Хур” системээр дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулган баталгаажуулах, холбогдогчийн өмнөх ял шийтгэл, гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг газар дээр нь шалгах боломжтой болгон шинэчилж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Дуудлага, мэдээлэл хүлээн авах үйл ажиллагаанд дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэлээр гал түймэр, гамшиг осол, гэмт хэрэг, зөрчил, эмнэлгийн түргэн тусламжийн дуудлага өгч байгаа иргэний гар утасны камерын дүрсийг мэдээлэл хүлээн авагч харах техникийн нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Тодруулбал, Иргэдээс гэмт хэрэг, зөрчил, гал түймэр, гамшиг осол, эмнэлгийн түргэн тусламжийн дуудлага, мэдээллийг хүлээн авах үед тухайн иргэний байршлыг өөрийнх нь зөвшөөрсний үндсэн дээр тодорхойлох технологийн шийдлийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр дуудлага өгч байгаа иргэн хаяг, байршлаа мэдэхгүй тохиолдолд мэдээлэл хүлээн авагчаас дүрст дуудлагын холбоос (link)-ыг богино зурвас (SMS)-аар илгээж, газрын зургийн “Google map” системд байршлын мэдээллийг харуулах боломжтой болгосон.

Мөн Нийслэлийн 6 дүүргийн Замын цагдаагийн хэлтсүүдийн бүсийн эргүүлүүдийн ашиглаж байгаа 24 таблет-д “X-GPS Tracker” аппелкайшин суурилуулах ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд бүсийн эргүүлээр ажиллаж байгаа алба хаагчдын байршлыг Шуурхай зохицуулалтын хэлтсийн байрнаас шууд хянах, ослын газарт цаг алдахгүй очих, дуудлага мэдээллийг зөв хуваарилах боломжтой болсон. Мөн гадаад иргэдийн эрхийг хамгаалах, цагдаагийн байгууллагын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор гадаадын иргэдээс 102 тусгай дугаарт ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийг Монгол хэл рүү “Ярих-Орчуулах” туршилтыг зохион байгуулж байна. Энэ

хүрээнд “Хэлмэрч” орчуулгын төхөөрөмжийг ашиглан интернеттэй орчинд 134, интернетгүй орчинд 20 гаруй улсын хэлийг бичиг болон зурган хэлбэрээр хөрвүүлэх боломжийг бүрдүүлэв.

Тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд ашиглах техникийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх чиглэлээр “Ухаалаг-Улаанбаатар хот” төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, Нийслэл хотын 135 уулзвар, 41 явганы гарц нийт 176 байршилд 2606 “AI” бүхий хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын камер, мөн замын хөдөлгөөнийг ерөнхий байдлаар харах зориулалт бүхий өндрийн 70 байршилд 360 градус хөдөлгөөнт байдлаар харах камеруудыг тус тус суурилуулж энэ оны 02 дугаар сараас “Замын хөдөлгөөний удирдлагын төв” УТҮГ дээр ашиглаж эхэлсэн. “IREX” ухаалаг систем дээр 142 уулзварт байрлуулсан 2377 зөрчил илрүүлэх теле камерын дүрст геометр тэмдэглэгээ оруулж, замын хөдөлгөөний дүрмийн нийт 5 зөрчил (гэрэл дохио, зогсох шугам, явган гарц, эгнээ байр, үргэлжилсэн шугам)-ийг ухаалгаар мэдэрч илрүүлэх боломжтой болгосон.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хотын зам, тээврийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх зорилгоор “Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд “Зам тээврийн ослын бүртгэл, мэдээллийн систем хөгжүүлж, суурилуулах зөвлөх үйлчилгээ STRA C-7” төслийг хэрэгжүүлж, TRL Technologies India Private Limited компанийн зүгээс “Зам тээврийн ослын бүртгэл, мэдээллийн шинэ платформ болон хөдөлгөөнт төхөөрөмжийн аппликейшн”-ыг хөгжүүлж хамтран ажиллаж байна. Энэхүү платформ нь зам тээврийн ослын мэдээллийг бүртгэхээс гадна, дүн шинжилгээ хийх, статистик тайлан мэдээ гаргахад зориулагдсан байна.

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвлөлөөс шаардагдах шийдвэрлүүлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын цагдаагийн газрын удирдлагатай уулзалтыг хийж тус улсын “GMD SOFT” компанийн хяналтын камерын дүрс бичлэгийг сэргээх, нягтралыг сайжруулах “MD-Video AI” программ, мөн зам тээврийн осол, хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хэргийн газраас бэхжүүлэн авсан фото зураг болон, дроны камерын бичлэг зэргийг осол үйлдэгдсэн үеийг сэргээн дүрслэх 3D зураглалд хөрвүүлэх Metashape программ хангамж болон 6 ширхэг дрон, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, ашигт малтмал хууль бусаар олборлож ой болон үзэгдэх орчин хязгаарлагдмал газар нуун далдалсан техник хэрэгсэл, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, мал, амьтныг олж тогтоох зорилгоор “DJ Matrice 350 RTK” маркийн дрон /нисгэгчгүй нисдэг төхөөрөмж/, “Zenmuse H20T” зэрэг камерыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, жирэмсэн эмэгтэйчүүдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг сайжруулах зорилгоор цагдаагийн байгууллагын алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын зэрэг нийт 63 байгууллагын үүдэнд “Тусламжийн хонх”-ыг суурилуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс дуудлага, мэдээлэл хүлээн авах зориулалт бүхий гар утасны “Tuslamj” аппликейшныг нэвтрүүлж, AppStore, GooglePlay-д байршуулан, ашиглалтын туршилт хийх ажлыг зохион байгуулж байна.

Хорих ял эдлээд суллагдсан болон хорихоос өөр төрлийн ялтай этгээдэд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр “Хурууны хээний биометр мэдээллээр бүртгэх программ”-ыг хур системтэй холбон шинээр үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын байгууллагатай хамтран яллагдагчид “Хяналтын төхөөрөмж ашиглан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ”-г хэрэгжүүлэх чиглэлээр хяналтын систем, программ хангамж, тоног төхөөрөмж /цахим бугуйвч/-ийг нэвтрүүлж, одоогийн байдлаар 75 яллагдагчид хяналтын төхөөрөмж ашиглан тухайн таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа сервер, сүлжээний тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах” судалж 20 төрлийн серверийн тоног төхөөрөмж болон төв орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн анги байгууллага дээр ашиглаж байсан нэгдсэн сүлжээний сүлжээний бүх тоног төхөөрөмжийг шинэчлэл хийхээр 290 нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж ажилласан.

ЕС. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь 2025 онд “Хамтдаа хөгжье” уриаг дэвшүүлэн, 7 зорилт хэрэгжүүлэхээр төлөвлөсний хоёрдугаар зорилтыг “Аюулгүй орчин – Урьдчилан сэргийлэх ажил” хэмээн тодорхойлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэдээлэл, судалгаанд үндэслэн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/176 дугаар тушаалаар Судалгаа, дүн шинжилгээний төвийг шинэчлэн байгуулж, урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлд чиглэсэн ажлыг шинэ түвшинд гаргах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Мөн аж ахуйн нэгж байгууллагад бүртгэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага мэдээлэл бүрийг тухайн байгууллагын регистрийн дугаараар бүртгэлжүүлэх зорилгоор дуудлага, мэдээллийн ECS desktop болон таблет төхөөрөмжид “Аж ахуйн нэгж байгууллагын регистрийн дугаараар бүртгэх” цонхыг шинээр үүсгэж, төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системтэй холболтыг хийсэн ба “Давтамжтай дуудлага” цэсэд аж ахуйн нэгж байгууллагын регистрийн дугаар дээр 2 болон түүнээс дээш удаа давтамжтай байдлаар бүртгэгдсэн дуудлага, мэдээллийг ангилан харах боломжийг бүрдүүлж, өгөгдлийн сантай болсон. Ингэснээр аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан давтамжтай дуудлага мэдээллийн судалгааг гаргах, түүний шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл, зөвлөмж, шаардлага хүргүүлэх ажил оновчтой зохион байгуулагдаж, энэ оны 05 дугаар сард бүртгэгдсэн дуудлага, мэдээлэл нь өмнөх сараас 13543 нэгжээр буюу 24,2 хувиар, өргөдөл, гомдол 4000 нэгжээр буюу хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Иргэдийн аюулгүй, тайван орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчил, хууль бус үйлдлийг урьдчилан илрүүлэх, хохирогч болох эрсдэлийг бууруулах зорилгоор “Ногоон бүс” төслийг 2023-2024 онд амжилттай хэрэгжүүлж, цагдаагийн байгууллагад ашиглагдаж буй Теле хяналтын камерын нэгдсэн санд 3 төрлийн, Мэдэгдлийн нэгдсэн санд 17 төрлийн, дуудлага мэдээллийн ECS программд 2 төрлийн тус тус нэмэлт өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Одоогийн байдлаар

Улаанбаатар хотын гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны хяналтын камеруудыг нэгтгэн зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын тамгын газрын дэргэд "Теле камерын хяналтын дэд төв", Нийслэлийн засаг даргын тамгын газрын дэргэд "Нэгдсэн удирдлагын төв"-ийг байгуулах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн.

Энэ оноос "Ухаалаг ногоон бүс" болгон өргөжүүлэн нийслэлийн 6 дүүргийн 6 хороог Юнител групптэй хамтран бүрэн камержуулах, ухаалаг программ хангамж, видео удирдлагын систем ашиглалтад оруулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна орчинд суурилуулсан хяналтын камерыг холбох тооцоо, судалгааг боловсруулж танилцуулж байна. Цаашид "Ухаалаг Ногоон бүс" салбар төслийг хэрэгжүүлж, аналитик хийх "IREX", олон төрлийн камерын дүрсийг нэгтгэн харах "NX WITNESS" нэгдсэн системийг нийслэлийн "Теле камерын хяналтын дэд төв"-ийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, эхний ээлжид нийтийн эзэмшлийн гудамж, талбайд гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг нийслэлийн төвийн 6 дүүргийн 6 хороо буюу Сүхбаатар дүүргийн 8, Хан-Уул дүүргийн 15, Чингэлтэй дүүргийн 2, Сонгинохайрхан дүүргийн 12, Баянзүрх дүүргийн 42, Баянгол дүүргийн 29 дүгээр хороодыг сонгон авч аж ахуй нэгж, байгууллагын болон улсын төсвөөр суурилуулсан теле камеруудыг дэд төвд нэгтгэн, сохор бүс буюу камерын хяналтад ороогүй хэсгүүдийг нэмэлтээр камержуулж, "Ногоон бүс" болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийг ESC программаас шүүж, нийт 3264 дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр 1145 давтамжтай дуудлага, мэдээллийн хөөн хэлэлцэх хугацаанд Эрүүгийн хуульд зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, урьдчилан сэргийлэх чиглэлээр эхний хагас жилд "Гэрлэлтийн гэрээ", "Хүчирхийлэлд хэн ч өртөх ёсгүй", "Хүн бүр мэдээлэх үүрэгтэй", "Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал таны амьдралын тулгуур", "Зөөлөн-Тэвчээртэй-Талархалтай", "Хувийн орон зайг хүндэтгэх хэрэгтэй", "Уучлал гэдэг үг олон харилцааг авардаг", "Гэр бүлийн хүчирхийлэл зөвхөн бие махбодын хүчирхийлэл биш", "Гэр бүлийн хүчирхийлэлгүй эрүүл харилцаа бусдын эрхийг хүндэтгэхээс эхэлдэг", "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг", "Сайхан харилцаа үүсгэх боломжоо алдалгүй, ярилцаж, ойлголцохыг хичээ", "Та бусдын хувийн болон гэр бүлийн амьдралыг хүндэтгээрэй", "Бие биедээ хүндэтгэлтэй байя", "Үг үйлдлээрээ үлгэрлэе, хатуу үг-хайхрамжгүй байдал нь хэзээ ч бүрэн эдгэрдэггүй", "Жендэр гэж юу вэ", "Асуудал юу ч байж болно", "Хүчирхийлэл шийдэл биш", "Аз жаргалтай харилцааны нууц", "Таны гэр хүчирхийллийн талбар биш", "Та бол түүний баатар", "Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг гэж", "Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт", "Хүүхдийнхээ дэргэд маргах нь хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг", "Харилцан хүндэтгэе" зэрэг агуулга бүхий видео контент 104, постер 113 мэдээлэл цахим хуудсанд байршуулсан нь нийт хандалт 12'258'064 байна.

Мөн цагдаагийн байгууллагын түр хамгаалах байранд нийт 46 гэр бүлийн 146 үйлчлүүлэгч /насанд хүрсэн эмэгтэй 46, эмэгтэй хүүхэд 51, эрэгтэй хүүхэд 50/-ийг хамгаалах байранд хүлээн авч, 43 гэр бүлийн 137 үйлчлүүлэгчийн /насанд хүрсэн эмэгтэй 38, эмэгтэй хүүхэд 48, эрэгтэй хүүхэд 47/ аюулгүй байдлыг ханган холбогдох байгууллага, албан тушаалтан, ар гэрт хүлээлгэн өгсөн, Одоогийн байдлаар 3 гэр бүлийн 9

үйлчлүүлэгч /насанд хүрсэн эмэгтэй 3, эмэгтэй хүүхэд 3, эрэгтэй хүүхэд 3/-ийг хамгаалан ажиллаж байна. Мөн энэ оны эхний хагас жилд 107 тусгай дугаарын утсанд 3529 иргэн хандсанаас хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөөг 569 иргэнд өгч Гэмт хэрэг зөрчлийн шинжтэй дуудлага 101 дуудлага мэдээлэл ирсэнээс Мэдээлэл шуурхай удирлагын 102 дугаарт 75, хөдөө орон нутгийн цагдаагийн газар хэлтэс нийт 26 дуудлага мэдээллийг дамжуулж шийдвэрлэлтийг авч ажилласан ба зөвлөгөө авсан 569 иргэний 402 иргэн Улаанбаатар хотоос, 122 иргэн хөдөө орон нутгаас, 44 иргэн хаяг тодорхойгүй хандсан байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 530 сургуулийн дунд, ахлах ангийн 99.118 сурагчдаас google forms программ ашиглан 14 асуулга бүхий цахим санал асуулга авч, АНУ-ын сайн туршлага болох “Sex offenders near me” веб хуудсыг Монгол улсад нэвтрүүлэх чиглэлээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан “Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэмт хэрүүдийн улмаас насанд хүрээгүй хүн, бага насны хүүхэд хохирсон хэргийн судалгаа (2020-2024)-ны ажлыг хийж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд танилцуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургуульд насанд хүрээгүй хүн, бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдсэн “Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэмт хэргийн талаар нэмэлт судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна.

Сургуулийн орчимд насанд хүрээгүй хүүхэд гэмт хэрэг, зөрчилд хамгийн ихээр өртөж, хохирсон талаарх судалгаанд суурилж, шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр Нийслэлийн ерөнхий боловсролын 9, Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 4 сургуульд “Мэдэгдэл” хүргүүлж, “Хүн бүр хүүхэд хамгаалагч” мэдээлэл, нөлөөллийн аяныг улсын хэмжээнд зохион байгуулж, дуудлага, мэдээллийн ECS программд хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн 270 давтамжтай дуудлагыг бүртгэн, нэгбүрчилсэн хяналт тавьж, Цахим орчинд насанд хүрээгүй хүний нэр төрд халдсан, гэмт хэрэг, зөрчилд уруу татсан бичлэгт хяналт тавьж, 6 фэйсбүүк пэйж хаягуудыг хаалгах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 134 постер, 121 рийл, 3 видео нийт 258 мэдээлэл байршуулсан нь 149.023 хүнд таалагдаж, 137.156 хүн бусдад түгээж, 19.017.713 цахим хэрэглэгчдэд хүрсэн хандалттай байна. Мөн @child_police_mongolia инстаграм хаягийг хөтөлж 41 постер, 67 рийл, 1 лайв бичлэгийг байршуулснаар 1.841.732 хүнд хүрсэн байна.

Мөн насанд хүрээгүй хүн, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдээс мэдүүлэг авах өрөөний үйл ажиллагаа, хүүхдийн цахим гадуурхалт, хүүхдийн цахим гадуурхалт, цахим орчны буруу хэрэглээ, хонхны баярыг тэмдэглэх үед хүүхдийг гэмт хэрэг, зөрчилт хохирохоос сэргийлэх, Ерөнхий боловсролын сургуулийн сурагч сургууль гэртээ очих замд хүүхдийн аюулгүй байдлыг хангах сэдвүүдээр 11 телевиз, сайтад 27 удаа мэдээлэл өгч, оршин суугаа газраасаа сураггүй алга болсон, төөрсөн мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх, богино хугацаанд олж тогтоох чиглэлээр СУ сүлжээ дэлгүүрийн кассын дэлгэцээр 104 хүүхдийн мэдээллийг дамжуулж, түргэн шуурхай олж тогтоон эцэг, эх, асран хамгаалагч нарт хүлээлгэн өгсөн байна.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хуулиар хориглосон мөрийтэй тоглоом зохион байгуулах, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр "Түлхүүр", "Амьдрал мөрий биш" арга хэмжээнүүдийг зохион байгуулан, мөрийтэй тоглоом зохион байгуулж байсан 7 газрыг илрүүлэн 75 этгээдийг бүртгэл судалгаанд авч ажилласан. Тайлангийн хугацаанд цахим орчинд мөрийтэй тоглоом зохион байгуулсан 4 бүлгийн 31 этгээдийн үйлдлийг тогтоож, дайчлан баривчилж, 7 төрлийн 6.9 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий үл хөдлөх хөрөнгө, 9 төрлийн 1 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий тээврийн хэрэгсэл, 150 сая төгрөгийн үнэлгээ бүхий утасны дугаар, 158 харилцах дансанд 2,48 тэрбум төгрөг, нийт 10.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг прокурорын зөвшөөрлөөр хязгаарлаж 26 этгээдийг яллагдагчаар татаж, мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Монгол Улсын Үндсэн Хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг хязгаарлах, хууль бус эргэлттэй тэмцэх, иргэдийг энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Анзаар-2", "Устгал", "Сөргөө", "Бүлэг-2025", "Туншил-2025", "Фест-2025" хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 10 тайчих үзүүлбэртэй шөнийн цэнгээний газарт хууль бус биеэ үнэлэлт зохион байгуулж, зуучилж байгаа эсэх, насанд хүрээгүй хүн ажиллуулж байгаа эсэхэд шалгалт хийж, 186 иргэнээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шинжилгээ хийж, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 6425 сурагчдад "Хорт зуршил ба донтолт" сэдвээр 48 удаагийн сургалт, Их, дээд сургуулийн 1002 оюутанд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хууль эрх зүйн хариуцлага" сэдэвт 24 удаагийн сургалт, эцэг, эх асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтан, байгууллагын эцэг эхийн зөвлөлийн 7158 иргэнд 46 удаагийн сургалт, тусгай чиг үүргийн байгууллагын 1541 алба хаагчдад "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нөхцөл байдал, таних арга, илрүүлэх техник хэрэгслийг ашиглах нь" сэдэвт 12 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Дураараа биш дүрмээрээ", "Сигнал", "Даатгал", "Уусан бол бүү жолоод", "Мотоцикл ба хамгаалах малгай", "Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал", "Зөрчилгүй жолооч", "Улсын дугаарын тэмдэг", "Орон нутгийн замын хөдөлгөөний соёл-2025", "Дүрмээ мөрдье" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу үйл ажиллагаа явуулж байгаа 576 шатахуун түгээх станцын 599 ширхэг камерын судалгааг гаргаж, цагдаагийн байгууллагын мэдээллийн сан <http://camera.police.gov/>-д бүртгэн газар зүйн байршлын систем narcgis.police.gov/ (ArcGis)-д бүрэн схем зураглал гаргасан ба шатахуун түгээх станцуудын үнийн самбарт авто замын зорчих хэсэг рүү харсан тус бүр 2 ширхэг камер нэмэлтээр суурилуулах, эвдрэлтэй камерыг засварлуулах, одоо ашиглаж байгаа камеруудыг теле камерын хяналтын дэд төвд холбох талаар 20 аж ахуй нэгжид албан бичиг тус тус хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Мөн Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын харьяа 21 анги, байгууллагын 2615 орчим ажилтанд 65 удаагийн сургалтыг зохион байгуулж,

төмөр замын аюултай бүсэд оршин суудаг 430 малчин өрхийн 1153 орчим иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэж, “Чингис Хаан”, “Буянт-Ухаа” Олон Улсын нисэх буудлуудаар Олон Улсын болон орон нутгийн 6301 удаагийн нислэгээр нийт 742682 зорчигч үйлчлүүлэх үед нийтийн хэв журам хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтад хяналт тавин, зөрчил дутагдалгүй үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын албаны даргаас Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн онцлох заалтуудыг иргэд, олон нийтэд сурталчлах замаар хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтыг улсын хэмжээнд “Хуулиа мөрдье”, “Цахим архи худалдаа”, “Тэнэмэл” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан. Гудамж талбай, олон нийтийн газар бүлэг бөөгнөрөл үүсгэж, архи дан согтуурдаг, орон гэргүй, тэнэмэл иргэдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирох, осгож нас барахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулж, **107** хүнийг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төв, “Дөлгөөн минж”, “Өлзийт асар” зэрэг төрийн бус байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газраас энэ оны эхний хагас жилийн байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйл “Татвар төлөхөөс зайлсхийх”, Монгол Улсын хилээр хууль бусаар олборлосон алтыг нэвтрүүлэх, худалдан борлуулах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, зорилгоор “Татвар”, “Акц-2025”, “Алт-2025” арга хэмжээг зохион байгуулан нийт 56 хэргийн санхүүгийн баримтад шинжилгээ хийж, 37 хэрэгт, 39 мөрдөгчийн магадалгаа, 8 мөрдөгчийн танилцуулга гаргаж удирдлага болон хариуцсан мөрдөгчид хүргүүлсэн.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, илрүүлэлтийг ахиулах чиглэлээр Төв, Хэнтий аймгийн цагдаагийн газар, Нийслэлийн Налайх, Багануур дүүргийн цагдаагийн хэлтсийн алба хаагч нартай бүсчилсэн зөвлөгөөнийг зохион байгуулан, “Малчин лавлах-109” төвд алдсан, олдсон 330 малын зарыг “Малчин телевиз”-ээр түгээж, нутаг дэвсгэрт хариуцсан цагдаагийн байгууллагын газар хэлтсүүдэд тухай бүр хүргүүлж, олж тогтоох чиглэлээр ажиллаж байна.

Хүрээлэн буй орчны гэмт хэрэг гарсан байршлыг өндөр нарийвчлалтайгаар тодорхойлох, эргэн тойрны нөхцөл байдлыг судлах, сэжигтэн болон гэрчийн маршрутыг тогтоох, алслагдсан байршилд биечлэн очихгүйгээр судалгаа хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор Google Earth болон интернет-газарзүйн мэдээллийн системийг ашиглан “мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа”-г зохион байгуулж, зайнаас тандан судлах АНУ-ын Махар, BlackSky хиймэл дагуулын өндөр нарийвчлалтай байр зүйн зургуудыг ашиглан ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн хууль бусаар ашигт малтмал олборлосон 9 аж ахуйн нэгжийн 129 га талбайг илрүүлж, энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухаан, технологийн ололтыг ашиглах нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, 8 оюутан, судлаачийн бүтээлийг шалгаруулж, Монгол Улсын Их сургуулийн Экологийн боловсролын төв, Ханнс Зайделийн сантай хамтран Нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргүүдийн ерөнхий боловсролын сургуулиудын 6-9 дүгээр

ангийн 350 сурагчид “Хууль бусаар ан агнах” гэмт хэргийн ойлголтын талаар сургалт зохион байгуулж, “Эко бүлгэм”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ажилласан.

Мөн химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Бодис-2025” арга хэмжээг 21 хоногийн хугацаанд зохион байгуулж, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт явуулж, “Химийн хорт, аюултай бодис импортлох, ашиглах, хадгалах, худалдан борлуулах” тусгай зөвшөөрөлгүй, нуугдмал байдлаар үйл ажиллагаа явуулж байсан 8 гэмт хэргийг илрүүлснээр энэ төрлийн хэргийн илрүүлэлт өмнөх оны мөн үеэс 42.9 хувиар өссөн байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шувуу” ажиллагаа эхлэхэд Интерполын “Улаан булант” зар мэдээгээр 22, “Хөх булант” зар мэдээгээр 70, нийт 92 иргэн эрэн сурвалжлагдаж байснаас өнөөдрийн байдлаар Интерполын “Улаан булант” зар мэдээгээр 14, “Хөх булант” зар мэдээгээр 60, Интерполд зарлагдаагүй 4, нийт 78 иргэнийг олж тогтоон олон улсын эрэн сурвалжлалтыг цуцалсан. Өнөөдрийн байдлаар Интерполын “Улаан булант” зар мэдээгээр 37, “Хөх булант” зар мэдээгээр 164, нийт 201 иргэн эрэн сурвалжлагдаж байгаагаас байгаа улс орон нь тогтоогдсон 78 иргэн байна.

Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр “Урьдчилан сэргийлэх албаны Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтэс”, “ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтэс” цахим хуудсуудад энэ оны эхний хагас жилийн байдлаар Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 90, Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 14, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 11, хар тамхины хор зуршлаас татгалзах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 44, мөрийтэй тоглоомын хор уршиг, урьдчилан сэргийлэх 80, зам тээврийн осол, гэмтэл, холбогдох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 6, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас үүсэх хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх 52, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 197, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 126, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд хүргэх чиглэлээр бэлтгэсэн 101, Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн талаар бэлтгэсэн эерэг 35, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаар 67, фото мэдээ 223, иргэнээс ирүүлсэн талархал 9, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран 97, инстаграм хуудаст 94, цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан 4, нийт 1’250 мэдээлэл бэлтгэн байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн нь 1’285’740 таалагдсан, 49’272 сэтгэгдэл үлдээсэн, 578’902 түгээсэн, 117’380’299 хандалт авсан байна.

АРАВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэмт хэргийн статистик мэдээллийн тоо, нөхцөл байдалд орон зайн дүн шинжилгээ хийж, “Системийн динамик загвар”-аар нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хэтийн төлөвийг 2045 он хүртэлх хугацаагаар тодорхойлж, дүн шинжилгээний ажилд ашиглаж байна.

Цагдаагийн байгууллага 2025 оны эхний 06 сард иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 163.656 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оноос 1673 буюу 1.0 хувиар өсөж, гэмт хэргийн шинжтэй 57.673 (35.2%), зөрчлийн шинжтэй 97.865

(59.8%) гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байна. Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 26.706, Улаанбаатар хотод 19.194 (71.9%), орон нутагт 7502 (28.0%), бусад газар (хилийн чанадад) үйлдэгдсэн 10 (0.1%) гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад улсын хэмжээнд нийт 6199 буюу 30 хувиар, нийслэлийн хэмжээнд 19.194 хэрэг буюу 35.5 хувиар, орон нутгийн хэмжээнд 7.502 хэрэг буюу 18.4 хувиар, бусад газар (хилийн чанадад)-т 10 хэрэг буюу 42.9 хувиар тус тус өссөн байна. Сүүлийн 10 жилийн дунджаар авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэрэг 6.5 хувийн өсөлттэй байна.

Гэмт хэрэг өссөн аймаг: Дундговь аймагт 74 гэмт хэрэг буюу 56.1 хувиар, Хэнтий аймагт 136 буюу 50.0 хувиар, Өвөрхангай аймагт 151 буюу 42.8 хувиар, Завхан аймагт 57 буюу 41.0 хувиар, Дархан-Уул аймагт 154 буюу 30.8 хувиар, Орхон аймагт 150 буюу 30.3 хувиар;

Гэмт хэрэг өссөн дүүргүүд: Нийслэлийн хэмжээнд Чингэлтэй дүүрэгт 769 гэмт хэрэг буюу 51.6 хувиар, Сонгинохайрхан дүүрэгт 906 буюу 49.8 хувиар, Баянгол дүүрэгт 1109 буюу 46.1 хувиар тус тус өссөн байгаа нь нийт 17 аймаг, 7 дүүрэгт 2.9 хувиас 56.1 хувиар өсөж, 4 аймаг, 2 дүүрэгт 2.8 хувиас 18.1 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 3520 буюу 13.2 хувь нь согтуугаар, 2396 буюу 9.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 727 буюу 2.7 хувь нь бүлэглэн, 497 буюу 1.9 хувь нь хүүхэд оролцож, 834 буюу 3.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 7670 буюу 28.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн 6839 буюу 89.2 хувь нь залилах гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 37.3 хувь, нийслэлд 33.5 хувь, орон нутагт 49.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 3.8 нэгжээр, нийслэлд 2.3 нэгжээр, орон нутагт 7.3 нэгжээр тус тус буурсан байна.

Хэрэг бүртгэлтийн 24.640 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6384 хэрэг буюу 35.0 хувиар, үүнээс 9186 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 1678 буюу 22.3 хувиар тус тус өссөн.

Холбогдогчдын 5468 буюу 21.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 447 буюу 8.9 хувиар өсөж, 1675 буюу 6.6 хувийг 0-17 насны хүүхэд эзэлж байгаа нь 81 буюу 5.1 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 24.592 иргэн, 100 хуулийн этгээд хохирч, үүнээс 567 хүн нас барж, 5680 хүн гэмтсэн нь өмнөх оноос нийт хохирогч 4945 буюу 25.2 хувиар, хуулийн этгээд 31 буюу 44.9 хувиар, нас барсан хүн 89 буюу 18.6 хувиар, гэмтсэн хүн 431 буюу 8.2 хувиар тус тус өссөн байна. Иргэн, хуулийн этгээдэд учирсан 398.2 тэрбум төгрөгийн хохирлын 127.7 тэрбум төгрөг буюу 32.1 хувийг нөхөн төлүүлж, 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд notice.police.gov цахим санг шинээр ашиглалтад оруулан, Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ оны эхний хагас жилд төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд нийт 18,840 мэдэгдэл, шаардлага, зөвлөмж, даалгавар хүргүүлж, Мэдэгдлийн нэгдсэн сан /notice.police.gov/-д бүртгэж ажилласан ба

үүнээс хуульд заасны дагуу биелэлтийн талаар 14,735 иргэн, хуулийн этгээдээс хариу авч, үр дүнг тооцож ажилласан.

Түүнчлэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй болон хангалтгүй биелүүлсэн 110 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх саналыг, мөн хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн 24 төрийн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага тооцуулах саналыг тус тус холбогдох байгууллагад хүргүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд 2 удаагийн хүсэлтийг гаргаж, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 771 иргэн, хуулийн этгээдэд нийт 636,970,000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулсан байна.

АРВАН НЭГ. НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Нийтийн хэв журмыг хамгаалж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба нь Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэдийн амар тайван амьдралыг баталгаажуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, итгэлтэй, найдвартай орчныг бүрдүүлэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед иргэдийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд нийт 137 удаагийн жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт зохион байгуулагдсанаас 114 буюу 83.21 хувь нь нийслэлд, 23 буюу 16.79 хувь нь орон нутагт тус тус зохион байгуулагдсан ба 120 буюу 88.32 хувь нь бүртгэлгүй явагдсан байна. Нийслэл хотод зохион байгуулагдсан жагсаал, цуглаанд 9.109 иргэн, 780 тээврийн хэрэгсэлтэй цуглаж, үзэл бодлоо илэрхийлэх үед 17 байгууллагын 3.892 алба хаагч, 461 тээврийн хэрэгсэлтэй, орон нутагт 1.198 иргэн, 407 тээврийн хэрэгсэлтэйгээр цуглаж үзэл бодлоо илэрхийлэх үед 9 байгууллагын 155 алба хаагч, 32 тээврийн хэрэгсэлтэй, нийт 26 байгууллагын 1.353 алба хаагч нийтийн хэв журмыг хамгаалж ажилласан.

Мөн улсын хэмжээнд нийт 2,391 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдсанаас 381 буюу 15.9 хувь нь нийслэлд, 2010 буюу 84.06 хувь нь орон нутагт тус тус зохион байгуулагдсан байна. Нийслэл хотод зохион байгуулагдсан арга хэмжээний үед давхардсан тоогоор 413,034 иргэн, 44,585 тээврийн хэрэгсэлтэй цуглах үед Цагдаагийн 17 байгууллагын 14,833 алба хаагч, 1,380 тээврийн хэрэгсэлтэй, орон нутагт зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээний үед 717,255 иргэн, 230,817 тээврийн хэрэгсэлтэйгээр цуглах үед 21 байгууллагын 8,648 алба хаагч, 2,451 тээврийн хэрэгсэлтэй, нийт 38 байгууллагын 23,481 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Дээрх зохион байгуулагдсан арга хэмжээнүүдийн үеэр эхний хагас жилийн байдлаар төрийн эрх бүхий байгууллага, иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагуудад 17, улс төрийн намуудад 9, иргэнд 11, нийт 37 шаардлага хүргүүлсэн.

Тайлант хугацаанд улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт 2 төрлийн өвчин /Гахайн африкийн мялзан, Хонины цэцэг/-ий 13 голомт, “Зооноз”-ын 4 төрлийн өвчин /Галзуу, Боом, Ям, Листероиз/-ий 83 голомт тус тус бүртгэгдэж, Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 35 дугаар зүйлийн 35.1.1, 45 дугаар зүйлд заасны дагуу Цагдаагийн байгууллаас мал амьтны өвчлөлийн үед хорио цээрийн дэглэм сахиулах, хүн

тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, хяналт тавих, өвчин гарсан бүс нутгаас малыг зөөвөрлөх, тээвэрлэх, нутаг дамжуулах, оторлох зэрэг үйл ажиллагаанд давхардсан тоогоор 36 алба хаагч, 14 тээврийн хэрэгсэлтэй, 840 хүн/цагийн үүрэг гүйцэтгэсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын энэ оны “Команд штабын сургуулийг зохион байгуулах тухай” А/22, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/34 дугаар тушаалын хүрээнд энэ оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс команд штабын сургуулилт 9 дүүргийн 39 цагдаагийн байгууллагын хүрээнд зохион байгуулагдаж, Улсын алба, төрийн цэргийн болон хууль сахиулах 18 байгууллагын 1106 алба хаагч хамрагдсан.

Мөн нийслэлийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн 151 мянга гаруй зөрчилд 5 тэр бум орчим төгрөгийн торгуулийг оногдуулж, шүүхээр 1591 хүнийг баривчлуулж, архидан согтуурч зөрчил гаргасан 1311 иргэнийг эрүүлжүүлж, архины албадан эмчилгээнд 170, сайн дурын эмчилгээнд 105 иргэнийг хамруулсан байна.

“Дүрс бичлэгийн техник хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгалт хийлгэх аж ахуйн нэгж, байгууллагуудын теле хяналтын камерыг Монгол Улсын стандарт MNS6423:2019 “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага”-ыг хангаж байгаа талаарх тодорхойлолт авахаар ирүүлсэн нийт 1236 хүсэлтийг хүлээн авч, нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн байгууллагад шилжүүлж, 867 хүсэлтийг зөвшөөрч, 317 хүсэлтийг татгалзаж, 35 хүсэлт хяналтад тавин ажиллаж байна.

АРВАН ХОЁР. ДОТООДЫН ЦЭРГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Цагдаагийн албаны тухай, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлэн ажиллалаа.

“Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-д үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны МН/181 дүгээр тушаалаар Цагдаагийн ерөнхий газар, Дотоодын цэргийн штабын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг тус тус шинэчлэн баталсантай уялдуулан албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчилж, байгууллагын хэмжээнд 846 орон тоог шинээр нэмэгдүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаас өгсөн үүрэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сум болон Орхон аймагт Монгол Улсын нийгэм, эдийн засагт онцгой ач холбогдол бүхий стратегийн үйлдвэр, орд газрыг түшиглэн Дотоодын цэргийн 2 ангийг, Улаанбаатар хотод террорист сөрөг тусгай ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чиг үүрэг бүхий Дотоодын цэргийн 1 ангийг тус тус шинээр байгуулсан.

Өнөөдрийн байдлаар Дотоодын цэргийн байгууллага нь штаб, 5 анги, 17 тусгай салбарын хүч хэрэгсэлтэйгээр хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Мөн Улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай байдлыг хангах зорилгоор үйл

ажиллагаандаа орчин үеийн хиймэл оюун ухаанд суурилсан техник технологи, камерын хяналтын нэгдсэн системийг нэвтрүүлж, удирдлага, хяналтын нэгдсэн төв болох “Дотоодын цэргийн шуурхай штаб”-ыг байгуулсан. Дотоодын цэргийн гүйцэтгэж буй чиг үүргийн онцлогт тохируулан Дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 141 дүгээр зарлигаар батлуулж, энэ онд үе шаттайгаар дүрэмт хувцасны хангалтыг хийж эхлээд байна.

Дотоодын цэргийн хамгаалалтад байгаа улсын онц чухал объектуудын харуул, хамгаалалтыг тайлант хугацаанд батлагдсан орон тооны хүч хэрэгслээр дүрэм, стандартын дагуу хэвийн зохион байгуулж, объектуудад давхардсан тоогоор 1290263 ажилтан, 570954 гадны иргэн, 5021 гадаадын иргэн, 442081 тээврийн хэрэгслийг тус тус шалган нэвтрүүлж, 436427 хөдөлгөөнийг бүртгэн хяналт тавьж, энэ оны эхний хагас жилийн байдлаар улсын онц чухал объектын хамгаалалтын бүсэд шалган нэвтрүүлэх журам зөрчсөн 659, зөрчлийн шинжтэй 100 гомдол мэдээллийг хүлээн авч, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, бэлэн бусаар 2881 зөрчилд 76.645.000 төгрөгийн торгууль оногдуулж ажилласан байна.

Энэ оны хагас жилд 6395,540 кг тэсэрч дэлбэрэх бодис, 4301343 метр, 4830316 ширхэг тэсэлгээний хэрэгслийг давхардсан тоогоор 55 дүүрэг, 174 аймгийн 159 сумын нутаг дэвсгэрт хүргэх нийт 361 удаагийн тээвэрлэлтийн хамгаалалтыг 809 дүгээр ангийн 483 алба хаагч нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэсэн.

Батлан хамгаалах яамнаас 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хугацаат цэргийн албаны цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангах хүрээнд зохион байгуулсан “Цэрэг татлага 2025” зөвлөгөөнд удирдах албан тушаалтан оролцож, хугацаат цэрэг татлагын зохион байгуулалтыг сайжруулах, Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хяналтын тоонд хүргэх, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал, цэрэг татлагын үеийн эрүүл мэндийн үзлэгт анхаарах зэрэг асуудлаар санал солилцлоо.

АРВАН ГУРАВ. БУСАД ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах үүднээс мод тарих, ургуулах, арчлах ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчлах, соён гэгээрүүлэх зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021 онд Зөв мод-зөв арчилгаа, 2022 онд Байгалиа бүтээе, 2023 онд Мод тарьж байгалиа бүтээе, 2024 онд Хүн бүр мод тарьцгаая, Алтан намар мод тарих цаг гэсэн аянуудыг улсын хэмжээнд амжилттай зохион байгуулж, 852 мэдээлэл бэлтгэн цахим хуудсанд байршуулсан нь давхардсан тоогоор 128.9 сая хандалт авч, улсын хэмжээнд 83.9 сая орчим мод таригдаад байна.

Энэ жилийн хувьд иргэдэд тарьсан модны тоогоор урамшуулах ажил зохион байгуулагдаж байгаатай холбоотойгоор хот суурин газарт ногоон байгууламж байгуулах тэр дундаа гэр хороолол, иргэд, олон нийтийг өөрийн эзэмшлийн хашаа, талбайд мод тарих, арчлах, ургуулах үндсэн чиглэл гаргаж, “Хашаандаа мод тарья” нөлөөллийн аяныг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран энэ оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж, аяны хүрээнд

нийт 251 мэдээ, мэдээлэл бэлтгэн цахим орчинд түгээсэн нь давхардсан тоогоор 505.010 цахим хэрэглэгчид таалагдаж, 635.189 удаа түгээгдэж, 16.076 сэтгэгдэл илэрхийлж, 26.353.579 хүнд хүрсэн байна. Нийт ирүүлсэн санал, сэтгэгдлийн 92.0 хувь нь дэмжсэн, 4.1 хувь нь шүүмжилсэн, 3.9 хувь бусад сэтгэгдлүүд байна.

Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас 2025 онд 120.000 мод тарихаар төлөвлөснөөс эхний хагас жилд нийт 6.358 алба хаагч, өөрсдийн сонгосон 192 байршилд хайлаас, улиас, агч, шар хуайс, гацуур, нарс, шинэс, бургас, голт бор, буйлс, жимсний мод зэрэг нийт 14 нэр төрлийн нийт 100.983 модыг тарьж, 50.4 га талбайг моджуулснаар зорилтот түвшин 84.1 хувьтай хангагдсан.

Монгол Улсад цэргийн дээд генерал цол олгож эхэлсний 81 жилийн ой, “Монгол генералын өдөр”-ийг зохион байгуулах, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 2024 оны А/221 дүгээр тушаалаар Тэргүүн дэд даргаар ахлуулан, бэлтгэл ажлын төлөвлөгөөг 4 бүлгийн 18 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Энэ ажлын хүрээнд 3 генерал цолтныг Nura оношилгооны төвд бүрэн шинжилгээ хийлгэж, 32 генерал цолтнуудад Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хамруулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын “Сүүж-Уул” нөхөн сэргээх сувилалд 16 генералыг гэр бүлийн хамт амрааж, 13 генерал цолтны албаны дүрэмт хувцсыг иж бүрдлийн дагуу шинээр оёулж, хүлээлгэн өгсөн

Мөн Ерөнхийлөгчийн ивээл дор эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, илтгэлүүдээр эмхэтгэл гаргах ажлын хүрээнд “Үндэстэн дамнасан аюул заналхийллийн эсрэг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа” сэдвийн хүрээнд олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд “Бидний цол Миний бахархал шүлгийн уралдаан зохион байгуулж, товхимол гаргах” чиглэлээр Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид, ахмад ажилтнуудын дунд “Бидний цол Миний бахархал” шүлэг, яруу найргийн уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгуулж, Дотоод хэргийн Их сургуулийн төв номын санг түшиглэн “Генералуудын булан” номын санг шинээр байгуулж, ахмад дунд залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх, уулзалтыг тус тус зохион байгуулж,

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас “Өнөөдөр сонго-Маргаашийг хамдаа бүтээе” уриатай нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг Сүхбаатарын талбайд энэ оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан.

Арга хэмжээний үеэр Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, бригадын генерал Т.Сүхболд сэтгүүлчтэй уулзалт зохион байгуулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын бодлого, шийдвэр цаашид хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл өгч, 8 төрлийн урлагийн тоглолтыг зохион байгуулж, “Open mic”, “Fatal vision goggles” ба согтууруулах ундааны нөлөө, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирох, үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж мэдээ, мэдээллийг тэдний насны онцлогт тохируулан өгөх зорилгоор “Алиалагч”, “Элбийн үзүүлбэр”, “Сэргийлэгч хүү, Зөвлөгч охины сургамж”, “Face art”, “Гар зургийн үзэсгэлэн”, “Хөл бөмбөг”, “Бүжгийн тэмцээн”-ийг сонирхолтой байдлаар зохион байгуулан ажилласан.

Тухайн арга хэмжээнд MNB, TV25, egale, NTV, TV5, SBN, C1, TV9, ETV зэрэг 10 телевиз, парламент, ikon, ergelt, neguur, eguur, zuv, isee, zugii, gogo, ubn зэрэг 20 мэдээллийн сайт, Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ зэрэг 3 сонин нийт 33 хэвлэл мэдээллийн байгууллагын захирал, ерөнхий ректор оролцож, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, “Police 102” аппилкейшнийг сурталчлах 7 төрлийн 2000 ширхэг сэрэмжлүүлэг, зөвлөмж болон арга хэмжээний хөтөч 1 төрлийн мэдээллийг 1000 ширхгийг хэвлэн тараасан.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР